

### Журамд нэмэлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1.1.1</sup>, 271<sup>1.1.17</sup> дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны ... дугаар сарын ..-ны өдрийн хуралдааны ... дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-д доорх нэмэлт оруулсугай:

1.1. “Тав. Гаалийн хилээр оруулах бараа, тээврийн хэрэгслийг мэдүүлэх, гаалийн хяналт тавих”-д “5.7<sup>1</sup>. “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8.1-д заасны дагуу тус хуулийн 10 дугаар зүйлд заасан хэлцлийн үнийн аргын шаардлагыг хангаж байгаа эсэхийг CAIS-ийн Гаалийн бүрдүүлэлтийн програмд шалгаж, хэлцлийн үнийг баталгаажуулж болно. Энэ тохиолдолд бичиг баримтанд шалгалт хийхгүй бөгөөд гаалийн мэдүүлэг “бичиг баримтын шалгалт хийсэн” төлөвт автоматаар шилжинэ.”;

1.2. “Арван гурав. Бусад”-д “13.11. Энэ журмын 5.7-д заасны дагуу CAIS-ийн Гаалийн бүрдүүлэлтийн програмаас шалгаж, хэлцлийн үнийг баталгаажуулсан тохиолдолд мэдүүлгийн бичиг баримтын бүрдүүлэлт, татварын тооцооноос үүдэн гарах хариуцлагыг мэдүүлэгч хүлээнэ.”

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Энхтайван)-д тус даалгасугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ